

ХӨХ

ГАН



ХНУКН

ГАН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20²⁶ оны 04 сарын 10 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн, 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “Хөх ган” ХК-ийн Төлөөлөн удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөх ган” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 14:00 цагт Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, “Нэхээсгүй Эдлэл” ХК-ийн байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - 2.1 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэх
 - 2.2 Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 - 2.3 ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - 2.4 Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай
 - 2.5 ТУЗ-өөс гаргасан Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуудах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 дахь өдөр буюу 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 3 дахь өдөр буюу 2025 оны 04 дугаар сарын 13-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2026 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-аар баталсугай. Хавсралт №3-т заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд “БиДиСек ҮЦК” ХК-ийн төв офис болон компанийн өөрийн байран дээр ирж танилцах боломжтой.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай.
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2026 оны 05 дугаар сарын 20-ны 14:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах хурлын даргаар Л.Бямбадорж, хурал зохион байгуулах комиссын даргаар Т.Болор-Отгон, гишүүнээр П.Мөнхтуяа, тооллогын комиссын даргаар П.Золжаргал, гишүүнээр Д.Энхмаа нарыг тус тус томилсугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах ажлыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг гүйцэтгэх захирал Л.Бямбадорж-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Б. МӨНХТӨР/

**“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистрийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Үнэт цаасны компани /

Брокерийн овог нэр

“Хөх ган” ХК-ийн **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал** 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо, “Нэхээсгүй Эдлэл” ХК-ийн 3 давхрын хурлын танхимд болно.

Саналын хуудас бөглөх заавар: **Дараах хэлэлцэх асуудлуудыг ЕРДИЙН АРГААР санал хураана.**

Ердийн аргаар саналаа өгөхөд асуудал бүрээр “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” аль нь болохыг тэмдэглэнэ.

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Санал
1.	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах;	Тогтоол №3				
2.	Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	Тогтоол №4				
3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох	Тогтоол №6				
4.	ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсөв батлах тухай	Тогтоол №5				
5.	ТУЗ-өөс гаргасан Ношдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах	Тогтоол №1				

Брокер: / /
/ гарын үсэг, тэмдэг /

Хувьцаа эзэмшигч: / /
/ гарын үсэг /

Саналын хуудсыг хүчинтэйд тооцов: /

Саналын хуудас хүчингүйд тооцсон бол шалтгаан:.....

.....

**"ХӨХ ГАН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Регистерийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо Кумулятив саналын тоо

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/

Брокерийн овог нэр

"Хөх ган" ХК-ийн **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал** 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо, "Нэхээсгүй Эдлэл" ХК-ийн 3 давхрын хурлын танхимд болно

№	ТУЗ-д нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо
Ердийн гишүүд		
1	Б.Мөнхтөр	
2	М.Цэлмэг	
3	С.Батзориг	
4	Д.Даянбилгүүн	
5	Б.Лхагвадорж	
6	С.Дөлгөөн	
Хараат бус гишүүд		
1	Д.Энхжин	
2	С.Дуламсанж	
3	Б.Алтансүвд	

Брокер: /
/гарын үсэг, тэмдэг /

Хувьцаа эзэмшигч: /
/гарын үсэг

ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. **Жишээ нь:** Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 11 гишүүнтэй байхад үүнээс 4 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 1100 саналын эрхтэй $/100 \times 11$ гишүүн $= 1100$ / болох бөгөөд үүнээс 700 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 7 хүртэл нэр дэвшигчид, 400 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 4 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн хуралд оролцож болно.
3. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаарх мэдээллийг 70104576, 95959105 утсаар лавлана уу.

Саналын хуудсыг **хүчинтэйд** тооцов: /

Саналын хуудас **хүчингүйд** тооцсон бол шалтгаан:

2026 оны ... сар ... өдөр

“ХӨХ ГАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 14:00 цагт эхэлнэ.

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	14:00-14:10
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	14:10-14:15
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	14:15-14:25
4	Хурлаар хэлэлцэх асуудлууд	
	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэх	14:25-14:35
	Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	14:35-14:45
	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	14:45-14:55
	Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай	14:55-15:05
	ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах	15:05-15:15
5	Асуулт хариулт	15:15-15:25
6	Саналын хуудас бөглөх заавар өгөх	15:25-15:30
7	Санал хураалт	15:30-15:45
8	Хурлын завсарлага	15:45-15:55
9	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	15:55-16:00
10	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	16:00-16:10
11	Хурлыг хаах (хурлын дарга)	16:10-16:15

Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын
материалын жагсаалт

1. 2025 оны Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан
2. 2026 оны Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө
3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга
4. ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлыг төсөв батлах
5. ТУЗ-өөс гаргасан Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийн танилцуулга

“ХӨХ ГАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Улаанбаатар хот, ХУД, 19-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 50-р байранд байрлах “Хөх Ган” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 05 сарын 20-ны өдөр 14:00 цагт болно.

Хурал зохион байгуулах газрын хаяг: ХУД, 19-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Нэхээсгүй Эдлэл” ХК-ийн байр, 2-р давхар, Хурлын танхим

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:
2026 оны 04 сарын 30-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэх
2. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
4. Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай
5. ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис болон компанийн өөрийн байранд хурал зохион байгуулах комиссын дарга Т.Болор-Отгон, гишүүн П.Мөнхтуяа нараас холбогдох мэдээллийг авч танилцах боломжтой.

Холбоо барих: 70104576, 95959105

И-мэйл хаяг: assistant.beren@gmail.com

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“Хөх ган” Хувьцаат Компани
Хаяг, утас:	Улаанбаатар хот, ХУД, 19-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Бэрэн цамхаг 50-р байранд байрлах “Хөх Ган” хувьцаат компанийн байр, Утас:70104576
Хурал хуралдах өдөр, цаг:	2026 оны 05 сарын 20 14:00 цагт
Хурал хуралдах газар: /хаяг, байршил/	Хан-Уул дүүрэг, 19-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Нэхээсгүй Эдлэл” ХК-ийн байр, 3-р давхар Хурлын танхимд
Хурлын төрөл:	Ээлжит бус
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	ТУЗ-ийн 2026 оны 04 сарын 10-ны өдрийн Тогтоол №02
Олон нийтэд зарлах огноо:	2026 оны 04 сарын 13, 2026 оны 04 сарын 28
Бүртгэх өдөр:	2026 оны 04 сарын 30-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг Үнэт цаасны компанид хүргүүлэх огноо:	2026 оны 04 сарын 30-ны өдрийн дотор
Хүргүүлсэн огноо:	2026 оны 04 сарын 13-ны өдөр
Хурлын даргын нэр:	Л.Бямбадорж
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга: П.Золжаргал, гишүүн: Д.Энхмаа
Баримт, бичгийн жагсаалт /Хавсралтаар/:	• ТУЗ-ийн тогтоол • ТУЗ-ийн Хурлын тэмдэглэл • ТУЗ-ийн гишүүдээс авах саналын хуудас • Нийтэд зарлах зарын загвар
Хурлын баримт бичгийн хуудсын тоо	ширхэг хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА  /Л.Бямбадорж/

2026 оны 04 сарын 10-ны өдөр